



I/2022

Тархаасан: 2022 оны 3 дугаар сарын 14



Дотоод худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 35.3 хувиар буурлаа

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард 2.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 622.9 (35.7%) тэрбум төгрөгөөр өслөө.

Үүнд хүнсний бүтээгдэхүүн, шатахууны бөөний болон жижиглэн худалдаа, эм, гоо сайхан, ариун цэврийн барааны жижиглэн худалдаа тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.3 (35.3) их наяд төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО¹, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар

	2019 I	2020 I	2021* I	2022* I	<u>2022* I</u> <u>2021* I</u>
	тэрбум төгрөг				хувь
Нийт	1 462.0	1 596.1	1 744.3	2 367.2	135.7
Бөөний худалдаа	464.4	614.5	712.7	960.0	134.7
Жижиглэн худалдаа	997.6	981.5	1 031.6	1 407.2	136.4

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын 2022 оны 1 дүгээр сарын борлуулалтын орлогын 40.6 хувь нь бөөний худалдаа, 59.4 хувь жижиглэн жижиглэн худалдааны салбарт ногдож байна.


Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард 1.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 375.6 (36.4%) тэрбум төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 960.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 247.3 (34.7%) тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.3 их наяд төгрөгөөр буурахад шатахууны жижиглэн худалдаа 190.4 (29.5%) тэрбум төгрөгөөр, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа 184.0 (56.1%) тэрбум төгрөгөөр, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн жижиглэн худалдаа 135.1 (43.0%) тэрбум төгрөгөөр, хүнсний төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа 126.9 (35.2%) тэрбум төгрөгөөр, хатуу, шингэн, хийн түлш, түүнтэй адил төстэй бүтээгдэхүүний бөөний худалдаа 98.3 (25.3%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 83.8 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалтын орлого 2022 оны 1 дүгээр сард 2.0 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 541.5 (37.6%) тэрбум төгрөгөөр өслөө.

Худалдааны салбарын борлуулалтын орлого Өмнөговь аймагт 2022 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар буурсан бөгөөд уул уурхай, үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн бөөний худалдаа, шатахууны жижиглэн худалдаа, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийн жижиглэн худалдаа тус тус буурсан нь нөлөөлсөн байна. Харин бусад аймгуудад 4.1-97.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО, аймгаар, жил бүрийн 1 дүгээр сарын байдлаар, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэл: Бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт: Тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр:

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код:

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь:

2022 оны 4 дүгээр сарын 13

Эдийн засгийн статистикийн газрын дарга А.Дэмбэрэл
 Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын статистикч Л.Энхбаатар
 Утас: (976-51)-264797